

НИЙГМИЙН ХАМГААЛЛИЙН ТУСГАЙ ТӨВ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН
ТЭМДЭГЛЭЛИЙН ТҮҮВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот


Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга		№	Зүйл, заалт	Хариуцах байгууллага	Биелэлт	Дүн
	1	2		3	4	5	6
1	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд	1	6	1.Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хууль зүйн үндэслэлтэй, шуурхай, гүйцэд эцэслэн шийдвэрлэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага нарт;	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нар	Иргэд, албан хаагчдаас 163 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч системд бүртгэж ажилласан. Үүнээс: -Шийдвэрлэсэн: 163 -Шийдвэрлэлтийн хувь: 100% байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 8 цаг 33 минут байна. Үйлчлүүлэгч иргэдээс түр хоноглох үйлчилгээнд хамрагдахыг хүссэн 873, тодорхой хугацаанд үйлчилгээ авч нийгэм сэтгэл зүй, эрүүл мэнд, ажлын байрны зуучлал хийгдэн байрнаас гарах хүсэлт 369 хүлээн авч тухай бүр нь цохолт хийн асуудлыг шийдвэрлэн ажилласан байна. 2025 онд иргэдээс ирсэн өргөдөл өмнөх оноос 10 дахин буурсан. Учир нь байгууллагад ирдэг өргөдлийн дийлэнх нь зорилтот бүлгийн иргэд байрлаж үйлчилгээ авах, түр хоноглох төвөөс гарах тухай агуулгатай байдаг. Энэ нь Нийслэлийн Засаг даргад ирдэг өргөдлийг 1000 гаруй тоогоор нэмэгдүүлдэг тул Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газрын ахлах мэргэжилтний зөвлөснөөр байгууллагын дотоод үйлчилгээ гэж үзэж байгууллагын системд оруулалгүйгээр холбогдох ажилтан хүсэлтийн дагуу иргэдэд байрлах үйлчилгээ үзүүлдэг болсон.	100%
2	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн	2	7	7.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг ханган, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал, хагас, бүтэн жилээр үнэлэж, дүгнэхдээ иргэдийн өргөдөл,	100%

	01 дүгээр хуралдааны тэмдэглэлд			дүгнэхэд иргэдийн өргөдөл, гомдол болон хариутай албан бичгийн шийдвэрлэлтийг харгалзан үзэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нарт;	удирдлага нар	гомдол болон хариутай бичгийн шийдвэрлэлтийг харгалзан ажилласан.	
3	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлд:	1	10	1.Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын бичиг баримт бүрдүүлэлтийг холбогдох журмын дагуу бэлтгэн хэлэлцүүлэхэд анхаарч ажиллахыг нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад;	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад		100%
4	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 06 дугаар хуралдааны тэмдэглэлд:	3	75	3. Авто зам, инженерийн дэд бүтэц, тохижилтын ажлын нөхөн сэргээлтийг зардлыг ажлын төсөв тоо хэмжээнд багтааж төсөвлөх, хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэхийг дүүргийн Засаг дарга нар, байгууллагын удирдлагуудад тус тус үүрэг болгов.” гэжээ.	Дүүргийн Засаг дарга нар, байгууллагын удирдлагуудад	Төвийн Түр хоноглох байрны ор, гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчлэх төсөл, тооцоо судалгааг боловсруулж, албан бичгээр 2025 оны 02 дугаар сард Дээрэт ОУ-ын Энэрлийн байгууллагад хүргүүлсэн бөгөөд оны төгсгөлд дээрх төсөл бүрэн хэрэгжсэн. Дээрэт ОУ-ын Энэрлийн байгууллагын Ази тивийн бүсийн менежер, Монголын талын Олон нийттэй харилцах албаны захирал С.Насанболд, Хүмүүнлэгийн салбар хариуцсан захирал Д.Пүрэвжаргал нарын төлөөлөл 11 сарын 11-ний өдөр Тусгай төвд зочилж, талуудын төлөөлөл хоёр байгууллагын хамтран хэрэгжүүлж буй Хүмүүнлэгийн халамжийн төслийн гэрээнд гарын үсэг зурах ёслолыг зохион байгуулж, тоног төхөөрөмжийг албан ёсоор хүлээлцсэн. Төслийн хүрээнд төвийн гал тогооны тоног төхөөрөмж, үйлчлүүлэгч иргэдийн ор, ус цэвэршүүлэгч зэрэг 54,6 сая төгрөгийн үнэ бүхий 58ш тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийж дэмжлэг үзүүлсэн. Тоног төхөөрөмж шинэчлэгдсэнээр зорилтот бүлгийн иргэд үйлчилгээ авдаг орчин нөхцөл	100%

						сайжирч, гал тогооны аюулгүй байдал, хоолны чанар сайжирч, үйлчилгээний сэтгэл ханамж нэмэгдсэн нь төслийн гол үр дүн юм. Түүнчлэн төвийн тохижилт, бүтээн байгуулалтын чиглэлд хамтран ажиллах тухай СХД-ийн ЗДТГ-т хуучин замын хавтанг төвд олгох тухай хүсэлт хүргүүлснээр төвд 40,000ш явган замын хавтан олгосон. Тус хавтангаар явган зам, тохижилтын ажил гүйцэтгэн ажиллаж байна.	
5	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 07 дугаар хуралдааны тэмдэглэлд:	1	94	Өргөдөл, гомдол гаргасан иргэдийг шийдвэрлэлтийн явц болон шийдвэрлэсэн тухай мэдээллээр хангаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлж байгаа иргэдийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээний агуулга, боловсруулалтын чанарыг сайжруулах, иргэдээс удаа дараа гаргаж байгаа гомдлын шалтгаан нөхцөлийг бодитой тодорхойлж, түүнийг бууруулах чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тусгаж ирүүлэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нарт	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нарт	Иргэд, албан хаагчдаас 163 өргөдөл, хүсэлтийг хүлээн авч системд бүртгэж ажилласан. Үүнээс: - Шийдвэрлэсэн: 163 - Шийдвэрлэлтийн хувь: 100% байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 6 хоног 8 цаг 33 минут байна. Үйлчлүүлэгч иргэдээс түр хоноглох үйлчилгээнд хамрагдахыг хүссэн 873, тодорхой хугацаанд үйлчилгээ авч нийгэм сэтгэл зүй, эрүүл мэнд, ажлын байрны зуучлал хийгдэн байрнаас гарах хүсэлт 369 хүлээн авч тухай бүр нь цохолт хийн асуудлыг шийдвэрлэн ажилласан байна. Түүнчлэн тайлангийн хугацаанд иргэдээс 1 гомдол 9 талархал байгууллагад ирсэн байна. Талархлыг хамт олонд танилцуулж, 1 гомдлыг хүсэлтийн дагуу, хуульд нийцүүлэн шийдвэрлэж ажилласан.	100%
6	Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 07 дугаар хуралдааны тэмдэглэлд:	5	98	5.Цаашид иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаа хэтрүүлэн шийдвэрлэхгүй байх, өргөдөл, гомдол шийдвэрлэх явцад зөрчил гаргахгүй, тайлан мэдээг дээд шатны байгууллагад хугацаанд нь тайлагнаж ажиллахад анхаарч, 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар дээрх зөрчил дутагдлыг гаргасан албан тушаалтнуудад	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нарт	Иргэдийн өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэж, ажилласан бөгөөд хугацаа хэтрүүлсэн өргөдөл гомдол 2025 онд гараагүй.	100%

				хариуцлага тооцсон тухай мэдээллийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлага нарт;			
7	Нийслэлийн засаг даргын зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 16 дугаар хуралдааны тэмдэглэлд:	1	204	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэгдсэн хуралдаан болон намын бүлгүүд, Хороодын хуралд өргөн мэдүүлж байгаа асуудлыг хэлэлцэхэд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын бүх шатны удирдлагууд холбогдох бэлтгэлээ хангаж, биечлэн оролцох, хүндэтгэн үзэх шалтгаангүй оролцоогүй байгууллагын удирдлагуудад хариуцлага тооцож ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (Д.Амгалан)-т үүрэг болгов." гэжээ.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нэгдсэн хуралдаан болон намын бүлгүүд, Хороодын хуралд өргөн мэдүүлж байгаа асуудлыг хэлэлцэхэд байгууллагын удирдлага холбогдох бэлтгэлийг хангаж, биечлэн оролцсон.	90%
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ДҮН							98,6%

ХЯНАСАН:
ДАРГА  Ш.МӨНХЦЭЦЭГ

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:
ТӨСЛӨ ХӨТӨЛБӨР, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЖИЛТАН  Э.ПҮРЭВСҮРЭН



НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ТУСГАЙ ТӨВ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙН ТҮҮВРИЙН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 12 дугаар сарын 05

Улаанбаатар хот

Нийгмийн хамгааллын тусгай төв 2025 онд Нийслэлийн Засаг Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлээс хамаарах 7 үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилласан.

Нийслэлийн Засаг Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хэрэгжилтийг Төсөл хөтөлбөр, хөдөлмөр эрхлэлт, олон нийттэй харилцах ажилтан Э.Пүрэвсүрэн нэгтгэж гаргасан.

Нийслэлийн Засаг Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам"-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн.

Үүрэг даалгаварын үнэлгээ/гүйцэтгэл		Нийт
Хяналтад авсан нийт үүрэг даалгаврын тоо		7
1	Хэрэгжсэн	6
2	Хэрэгжилт дутуу	1
Хэрэгжилтийн дундаж дүн		100

$$\text{Үүрэг даалгаварын хэрэгжилтийн ерөнхий дүн} = \frac{6}{7-1} \times 100\% = 100\%$$

Нийгмийн хамгааллын тусгай төвийн хариуцах 2025 оны Засаг Даргын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хэрэгжилтийн ерөнхий дүн 100% тай хэрэгжсэн байна.

ХЯНАСАН:

ДАРГА  Ш.МӨНХЦЭЦЭГ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

АХЛАХ НИЙГМИЙН АЖИЛТАН

ДОТООД ХЯНАЛТ



Б.НАНДИНЦЭЦЭГ